

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Есөнбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/120/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Алтай хот
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjdmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: Э.Сүнжидмаа
Утас: 80048599 Цахим хаяг: Sunjdmaae@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.24 № 81

танай _____ -ны № _____ -т

Сөрөг санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар ээлжийн амралт цалин давхардуулан олгосон, өндөр насны тэтгэвэрт гарсан ажилтны тэтгэмжийн илүү, дутуу тооцон олгосон, эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн, цалингийн зардлаас үйлдвэрчний эвлэлийн татвар суутгаж шилжүүлээгүй, нярав, нягтлан бодогчийн дансаар дамжуулан гүйлгээ хийсэн, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй.

Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгээгүй, хөрөнгийг дансны ангилал зөрүүтэй бүртгэсэн, төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгө бараа материалыг орлогод аваагүй, санхүүгийн тайланд авлага, өглөгийг тусгаагүй, газрыг үнийн дүнг зөрүүтэй бүртгэсэн, Засаг даргын нөөц хөрөнгөөс бэлэг дурсгал, туршлага солилцох зардлыг санхүүжүүлсэн, шилэн дансны сайтад мэдээллийг бүрэн байршуулаагүй, төсвөөс автомашины торгууль төлсөн, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ажлын даалгаврыг боловсруулаагүй, авлагыг барагдуулаагүй, Төрийн аудитын байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлээгүй 1,519,416.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.

0702900292

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 14 дүгээр зүйлийн 14.4, 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5, 22 дугаар зүйлийн 22.1, 24 дүгээр зүйлийн 24.4, 29 дүгээр зүйлийн 29.4 41 дүгээр зүйлийн 41.12.2, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 12 дугаар зүйлийн 12.1, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дахь заалттай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд ажилчдын ажиллаж нөхцөлийн сайжруулах арга хэмжээ авч, шаардлагатай компьютер, тоног төхөөрөмжөөр хангаж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Тайланд оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг төсвийн хэлбэлзлийн тайлангийн дүнгээр шивж бэлтгэсэн байна.

Бусад асуудал

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж сумын засаг дарга 98.0 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	179,325.6	179,415.6
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,686,524.1	1,564,919.2
Нийт хөрөнгийн дүн	1,865,849.7	1,744,334.8
Нийт өр төлбөрийн дүн	4,106.7	4,106.7
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,861,743.1	1,740,228.1
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,865,849.7	1,744,334.8
Үйл ажиллагааны орлогын дүн	2,539,610.8	3,793,390.3
Үйл ажиллагааны зардлын дүн	2,502,951.7	3,914,905.2
Үйл ажиллагааны үр дүн	36,659.1	-121,514.9
Үйл ажиллагааны бус үр дүн		
Үйл ажиллагааны нийт үр дүн	36,659.1	-121,514.9
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,825,083.8	1,862,144.0
Тайлант оны үр дүн	36,659.1	-121,514.9
Эцсийн үлдэгдэл	1,862,144.0	1,740,228.1
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,342,116.4	3,709,331.1
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,339,116.4	3,280,424.2
Үйл ажиллагааны ЦМГ	3,000.0	245,086.9
Хөрөнгө оруулалтын ЦМГ	3,000.0	245,086.9
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	3,000.0	245,086.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,890,440.1	3,277,316.9
Урсгал зардал	1,890,440.1	3,277,316.9
Хөрөнгийн зардал		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,930,809.2	3,279,602.3
Улсын төсвөөс санхүүжих		
Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,930,809.2	3,279,602.3

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулагдаагүй нийт 1,519,416.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их аудитын хангалттай ба зохистой нотолгоог хангалтгүй, санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөлөл өндөр тул "Сөрөг" санал дүгнэлт өгсөн.

Аудитаар 9,309.4 мянган төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, 1,285,189.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 15 албан шаардлага, 224,918.0 мянган төгрөгийн 5 зөрчилд 4 албан тушаалтныг хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн байна.

5.1 Төлбөрийн акт

1. Ажилтнаас 200.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу тооцож суутгасан урьдчилгааг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон

2. Ээлжийн амралт, цалин давхардуулан 5 ажилтанд 1,095.3 мянган төгрөгийг илүү тооцож олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.1-т "Ээлжийн амралтын цалинг ажилтны тухайн ажлын жилийн дундаж цалин хөлснөөс тооцож олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/19 дүгээр тушаалын хавсралтын 3 дугаар зүйлийн 3.4-т "Ээлжийн амралтын цалинг тооцохдоо өмнө эдэлсэн ээлжийн амралтаас хойш ажилласан саруудын цалин хөлсний нийлбэрийг, тухайн саруудад ажилласан ажлын өдрийн нийлбэр тоонд хуваан ажлын нэг өдрийн дундаж цалин хөлсийг гаргаж ээлжийн амралтын өдрөөр үржүүлж бодно" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Амралт цалин давхардуулан олгосон мөнгийг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон

3. Ажилчдаас суутгасан үйлдвэрчний эвлэлийн татвар 766.1 мянган төгрөгийг дутуу шилжүүлсэн нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах,"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу төвлөрүүлсэн мөнгийг Есөнбулаг сумын үйлдвэрчний эвлэлийн дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон

4. Автомашины торгууль 240.0 мянган төгрөгийг төсвөөс төлсөн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвөөс авто машины торгууль төлсөн мөнгийг төлүүлж төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон

5. Ажилчдын цалингаас хамтын сан гэх нэрээр 6,420.0 мянган төгрөгийг суутгасан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1-т "Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно: 119.1.1.ажилтны нэг сарын дундаж цалин хөлснөөс хэтрэхгүй хэмжээний хохирлыг ажилтнаар нөхөн төлүүлэх тухай ажил олгогчийн шийдвэр гарсан; 119.1.2.шүүхийн, эсхүл хөдөлмөрийн эрхийн маргаан шийдвэрлэх байгууллагын шийдвэр хүчин төгөлдөр болсон; 119.1.3.ажилтанд энэ хуулийн 123.2.3-т заасан хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулсан; 119.1.4.хууль тогтоомжид заасан бусад тохиолдол" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилтнуудаасаа суутгасан мөнгийг буцаан олгох төлбөрийн акт тогтоосон

5.2 Албан шаардлага

1. Данс бүртгэлд нэгээс дээш жилийн насжилттай 86,763.4 мянган төгрөгийн авлага баталгаажуулаагүй бүртгэлтэй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах,"; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх", гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Авлагын тооцоо нийлж, барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулан ажиллах албан шаардлага хүргүүлсэн

2. Нийгмийн даатгалын тайланд цалинг 8,639.9 мянган төгрөгөөр илүү тооцож тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах"; 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх"-гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Нийгмийн даатгалын тайланг үнэн зөв тайлагнаж, тооцоо нийлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн

3. Эдийн засгийн ангилал зөрчиж цалингийн нөхөн олговор 10,734.9 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлэх зардлаас, Засаг даргын нөөц хөрөнгө 1,986.0 мянган төгрөгийн, төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас, компьютер 3,135.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас санхүүжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй байна" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Төсвийг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлсэн

4. Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор үндсэн хөрөнгө 487,608.9 мянган төгрөгөөр, бараа материал 12,966.9 мянган төгрөгөөр зөрүүтэй, нягтлан бодогч тооцоо бодоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1. жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх"-гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Хөрөнгийн тооллогыг чанартай хийж тооцоог бодох албан шаардлага хүргүүлсэн.

5. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийг тулгаж үзэхэд барилга байгууламж дансанд бие засах газар, бусад байгууллагын шугам сүлжээ, тоглоом, зам талбай 210 123.7 мянган төгрөгийн, тавилга, аж ахуйн эд хогшил дансанд төрийн сүлд, угаалын машин, хогийн сав, ус буцалгагч, 2,569.0 төгрөгийн, нийт 212,692.7 мянган төгрөгийн хөрөнгийн дансны ангилал зөрүүтэй бүртгэсэн нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэлт: Хөрөнгийн ангилал зөрүүтэй зөрчлийг арилгаж, бүртгэл хөтөлөлтийг сайжруулах албан шаардлага хүргүүлсэн

6. Нэмэлт санхүүжилтийн дансаар хийгдсэн 49,400.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 тохижилтын ажлыг тоо хэмжээ, ажлын даалгаваргүй байхад гүйцэтгүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөд, арга хэмжээг тусгана. Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.3.3-т Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөд, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ

хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх;" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Хөрөнгийн Ажлын даалгавар, техник эдийн засгийн тооцоололгүй хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхгүй байх албан шаардлага хүргүүлсэн

7. Компьютер 3,135.0 мянган төгрөг, хаалга 1,600.0 мянган төгрөг, хогийн сав 16,000.0 мянган төгрөг, камер 2,593.2 мянган төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд орлого аваагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"-гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Нягтлан бодох бүртгэлд хөрөнгийг орлого авч, бүртгэлд тусгах албан шаардлага хүргүүлсэн

8. Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд 31,855.4 мянган төгрөгийг дутуу шивсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ"- гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Татварын нэгдсэн системд баримтыг нөхөн шивүүлэх албан шаардлага хүргүүлсэн

9. Өндөр насны тэтгэвэрт гарсан 3 ажилтны тэтгэмжийг давтан тооцож үзэхэд 2 ажилтанд 13,431.4 мянган төгрөгийг илүү, 1 ажилтанд 425.2 мянган төгрөгийн дутуу тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т "Төрийн албаны тухай хуулиас бусад хуульд албан хаагчид тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгохоор заасан бол албан хаагч тэдгээрээс аль илүүг сонгох эрхтэй бөгөөд давхардуулан олгохгүй", Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын 5 дугаар зүйлийн 5.4-т "Төрийн албан хаагчийн ажиллаж байсан байгууллагын дарга, хүний нөөц болон санхүү хариуцсан ажилтнууд энэ журмын дагуу тухайн төрийн албан хаагчийн төрийн алба хаасан хугацаа, үндсэн цалинг үнэн зөв тодорхойлох үүрэг хүлээнэ"- гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Тэтгэмжийг дахин тооцоолон тооцоо нийлж төсөвт учирсан хохирлыг барагдуулах албан шаардлага хүргүүлсэн

10. Санхүүгийн тайланд хувь хүний орлогын албан татвар 25,804.0 мянган төгрөгийн өглөг, нийгмийн даатгалын шимтгэлийн 522.2 мянган төгрөг, шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговор 12,574.4 мянган төгрөгийг авлагад бүртгээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"; 14.4.3-т "бүх өр төлбөр"; 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарь болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх"-гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Авлага, өглөгийг нягтлан бодох бүртгэлд тусгаж, барагдуулах арга хэмжээг авах албан шаардлага хүргүүлсэн

11. Тээвэр шатахууны зардалд 38,581.1 мянган төгрөг, урсгал засварын зардал 48,892.2 мянган төгрөг, багаж техникийн зардал 37,985.0 мянган төгрөгийг зарцуулсан хэдий ч худалдан авах

ажиллагаа зарлаагүй нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно"- гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулах албан шаардлага хүргүүлсэн

12. Нягтлан бодох бүртгэлд газрыг үнийг 6,553.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана"- гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Нягтлан бодох бүртгэлд зөрүүг залруулан бүртгэх албан шаардлага хүргүүлсэн

13. Алтай хотын нийтийн зорчигч тээвэрлэлтийг гүйцэтгэх гэрээний дагуу 64,814.8 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон хэдий гүйцэтгэлийг үнэлж тооцоолоогүй, нөхэмжлэхийн дагуу шилжүүлсэн, Үнэлэмж-Алтай ХХК нь мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй компаниар гэрэлтүүлгийн урсгал засвар үйлчилгээ хийлгэж 54,501.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6-т "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх"; 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Анхан шатны баримтыг үндэслэн гүйлгээг хийж, зохих зөвшөөрөл бүхий этгээдтэй гэрээ байгуулах албан шаардлага хүргүүлсэн

14. Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын аварга малчид шагнал, бэлэг дурсгалын зүйлд 11,957.3 мянган төгрөг, байгууллага туршлага судлахад 10,954.2 мянган төгрөгийн, анхан шатны баримт тодорхойгүй 11,463.8 мянган төгрөгийн, байгууллагын шинэ жилийн үйл ажиллагаанд 2,000.0 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"; 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"- гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Төсвийг хэмнэлттэй үр ашигтай байхаар төлөвлөн зарцуулж албан шаардлага хүргүүлсэн

15. Санхүүгийн тайланд 1,183,605.0 мянган төгрөгийн гүйлгээг төсвийн хэлбэлзлийн тайлангаар хагас жилийн тайлан гаргасан, аудитын явцад тайланг засварлаж ирүүлэхдээ тайлант үеийн үр дүнг 49,570.0 мянга төгрөгөөр өсгөж, өглөгийг 34,893.3 мянган төгрөгөөр, бараа материалын тайланг 14,751.4 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгийн тайланг 3,165.4 мянган төгрөгөөр тус тус бууруулж тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана."- гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Нягтлан бодох бүртгэлийг стандарт журмын дагуу хөтлөх, түүнд тавих хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлсэн

16. Зарцуулалт тодорхойгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй, хангалтгүй 158,609.5 мянган төгрөгийн гүйлгээ

Няравын дансаар 13,382.9 мянган төгрөгийн, нягтлан бодогчийн дансаар 900.0 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн.

Түлш шатах тослох материал, сэлбэг хэрэгслийн эд хариуцагчийн тайлан гаргаагүй, бичиг хэргийн тайлан нягтлан бодох бүртгэлээс орлого 8,792.6 мянган төгрөг, зардал 8,293.5 мянган төгрөгийн, аж ахуйн материалын тайлангийн орлого 23,930.2 мянган төгрөг, зардал 8,217.0 мянган төгрөгийн, барилгын засварын материал тайлангийн орлого 12,079.8 мянган төгрөг, зардал 12,442.7 мянган төгрөгөөр, мал амьтад 2,200.0 төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно". 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр", 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр,"; 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;" Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралтын 9 дүгээр зүйлд "Бараа материалын тайланг агуулахын нярав, эд хариуцагч нь аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана. Бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нар дээр хөтлөгдөж буй агуулахын бүртгэлтэй тулган шалгаж хүлээж авна", -гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн Есөнбулаг сумын Санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтэн, нярав нарт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж албан шаардлага хүргүүлсэн

17. Төрийн аудитын байгууллагаас тогтоосон 2023 оны 01/103-07/103 дугаартай төлбөрийн акт, 2018 оны 03/49, 2021 оны 02/149, 05/149, 2023 оны 01/139-12/139 дугаартай албан шаардлагуудыг хэрэгжүүлээгүй, уг зөрчлийг давтан гаргасан.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэлд хийсэн аудитаар сөрөг дүгнэлт авсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Сөрөг санал дүгнэлт авсан, өмнөх шийдвэр биелүүлээгүй, албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын төсөв захирагчид хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж албан шаардлага хүргүүлсэн

Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4.00	5	6.00	7	8.00	9	10	11	12
	Ажилтнаас 200.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаагүй	1	200.00	1	200.00						
	Эзлэгийн амралт, цалин давхардуулан 5 ажилтанд 1,095.3 мянган төгрөгийг илүү тооцож олгосон	1	1,095.30	1	1,095.30						
	Ажилчдаас суутгасан үйлдвэрчний эвлэлийн татвар 766.1 мянган төгрөгийг ДУТУУ шилжүүлсэн	1	766.10	1	766.10						
	Автомашинны торгууль 240.0 мянган төгрөгийг төсвөөс төлсөн	1	240.00	1	240.00						
	Ажилчдын цалингаас хамтын сан гэх нэрээр 6,420.0 мянган төгрөгийг суутгасан	1	6,420.00	1	6,420.00						
	Хантайшир-100 жилийн ойгоор ажилласан ажилчдад олгосон цалин тэтгэмжээс 588.0 төгрөгийн ашгийн татвар суутган тооцсон боловч төсөвт төвлөрүүлээгүй.	1	588.00	1	588.00						
	Данс бүртгэлд нэгээс дээш жилийн насжилттай 86,763.4 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй	1	-			1					



Есенбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Нийгмийн даатгалын хэлтэст цалинг 8,639.9 мянган төгрөгөөр илүү тооцож тайлагнасан	1	8,639.60				1	8,639.60	-	-	-
Эдийн засгийн ангилал зөрчиж цалингийн нөхөн олговор 10,734.9 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлэх зардлаас, засаг даргын нөөц хөрөнгө 1,986.0 мянган төгрөгийн, төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас, компьютер 3,135.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас санхүүжүүлсэн	1	15,855.90				1	15,855.90			
Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор үндсэн хөрөнгийг 487,608.9 мянган төгрөгөөр, бараа материалыг 12,966.9 мянган төгрөгөөр зөрүүтэй хийсэн, нягтлан бодогч тооцоо бодоогүй	1	500,575.80				1.00	500,575.80	-	-	-
Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийг тулгаж үзэхэд барилга байгууламж дансанд бие засах газар, бусад байгууллагын шугам сүлжээ, тоглоом, зам талбай 210,123.7 мянган төгрөгийн, тавилга, аж ахуйн эд хогшил дансанд төрийн сүлд, угаалын машин, хогийн сав, ус буцалгагч, 2,569.0 төгрөгийн, нийт 212,692.7 мянган төгрөгийн хөрөнгийн дансны ангилал зөрүүтэй бүртгэсэн	1	212,692.70				1.00	212,692.70			
Нэмэлт санхүүжилтийн дансаар хийгдсэн 49,400.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 тохижилтын ажлыг тоо хэмжээ, ажлын даалгаваргүй байхад гүйцэтгүүлсэн	1	49,400.00				1.00	49,400.00			



Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Компьютер 3,135.0 мянган төгрөг, хаалга 1,600.0 мянган төгрөг, хогийн сав 16,000.0 мянган төгрөг, камер 2,593.2 мянган төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд орлого аваагүй	1	23,328.20					1.00	23,328.20		
Өндөр насны тэтгэвэрт гарсан 3 ажилтны тэтгэмжийг давтан тооцож үзэхэд 2 ажилтанд 13,431.4 мянган төгрөгийг илүү, 1 ажилтанд 425.2 мянган төгрөгийн ДУТУУ тооцож олгосон	1	13,856.60					1.00	13,856.60		
Санхүүгийн тайланд хувь хүний орлогын албан татвар 25,804.0 мянган төгрөгийн өглөг, нийгмийн даатгалын шимтгэлийн 522.2 мянган төгрөг, шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговор 12,574.4 мянган төгрөгийг авлагад бүртгээгүй	1	38,900.60					1.00	38,900.60		
Тээвэр шатахууны зардалд 38,581.1 мянган төгрөгийн урсгал засварын зардал 48,892.2 мянган төгрөг, багаж техникийн зардал 37,985.0 мянган төгрөгийг зарцуулсан хэдий ч худалдан авах ажиллагаа зарлаагүй	1	125,458.30					1.00	125,458.30		
Нягтлан бодох бүртгэлд газрыг үнийг 6,553.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн	1	6,553.00					1.00	6,553.00		

Есенбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	<p>Алтай хотын нийтийн зорчигч тээвэрлэлтийг гүйцэтгэх гэрээний дагуу 64,814.8 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон хэдий гүйцэтгэлийг үнэлж тооцоолоогүй, нэхэмжлэхийн дагуу шилжүүлсэн, Үнэлэмж-Алтай ХХК нь мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй компаниар гэрэлтүүлгийн урсгал засвар үйлчилгээ хийлгэж 54,501.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож байгаа</p>	1	119,316.60	1.00	119,316.60					
	<p>Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын аварга малчид шагнал, бэлэг дурсгалын зүйлд 11,957.3 мянган төгрөг, байгууллага туршлага судлахад 10,954.2 мянган төгрөгийн, анхан шатны баримт тодорхойгүй 11,463.8 мянган төгрөгийн, байгууллагын шинэ жилийн үйл ажиллагаанд 2,000.0 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан</p>	1	36,375.30	1.00	36,375.30					
	<p>Аудитад ирүүлсэн санхүүгийн тайланд 1,183,605.0 мянган төгрөгийн гүйлгээг хэлбэлзлээр хагас жилийн тайлан гаргасан, аудитын явцад тайланг засварлаж ирүүлэхдээ тайлант үеийн үр дүнг 49,570.0 мянга төгрөгөөр өсгөж, өглөгийг 34,893.3 мянган төгрөгөөр, бараа материалын тайланг 14,751.4 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгийн тайланг 3,165.4 мянган төгрөгөөр тус тус бууруулж тайлагнасан</p>	1	102,380.10	1.00	102,380.10					



Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Түлш шатах тослох материал, сэлбэг хэрэгслийн эд хариуцагчийн тайлан гаргаагүй, бичиг хэргийн тайлан нягтлан бодох бүртгэлээс орлого 8,792.6 мянган төгрөг, зардал 8,293.5 мянган төгрөг, аж ахуйн материалын тайлангийн орлого 23,930.2 мянган төгрөг, зардал 8,217.0 мянган төгрөг, барилгын засварын материал тайлангийн орлого 12,079.8 мянган төгрөг, зардал 12,442.7 мянган төгрөгөөр, мал амьтад 2,200.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1	52,025.60	1.00	52,025.60					
Няравын дансаар 13,382.9 мянган төгрөгийн, нягтлан бодогчийн дансаар 900.0 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна.	1	14,282.90	1.00	14,282.90					
Зарцуулалт тодорхойгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй, хангалтгүй 158,609.5 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна.	1	158,609.50	1.00	158,609.50					
Нийт	23	1,487,560.10	6	9,309.40	17	1,478,250.70	0	-	-



Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

/Мянган

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагы н нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн н акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Есөнбулаг сумын Засаг даргын тамгын газар	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс 31,855.4 мянган төгрөгийн и-баримтгүй худалдан авалт хийсэн. Шилэн дансанд байршуулах 5 саяас дээш орлогын 2,473,780.7 мянган төгрөгийн 59 гүйлгээ, 5 саяас дээш үнийн дүн бүхий 827,204.4 мянган төгрөгийн зарлагын 42 гүйлгээ, төсөв өмч, хөрөнгө зарцуулах 12,340.0 мянган төгрөгийн 14 гүйлгээг мэдээлээгүй байна.	1	31,855.4			1	31,855.4	-	-	-	-
	Нийт	1	31,855.4	0	-	1	31,855.4	-	-	-	-

